

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт, ерөнхий шаардлага.	MNS 4969 : XXXX
Occupational safety and health. General requirement for organisation of training	MNS 4969 : 2000-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сургалтыг сургуулийн өмнөх насны хүүхэд, бүх шатны сургуулийн суралцагчид, шинээр давтан, хоёр дахь мэргэжлээр бэлтгэгдэж байгаа болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, инженер, техникийн болон удирдах ажилтанд зориулж, шат шатанд нь зохион байгуулна.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

MNS ISO 45001, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо – Шаардлага, хэрэглэх заавар*

MNS 6768, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага*

MNS 6658, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байранд эрдсийн тоосны өртөлтөөс ажилтныг хамгаалахад тавих ерөнхий шаардлага*

MNS 6654, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага*

3 Ерөнхий зүйл

3.1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн дээд боловсрол, үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх сургалтын тогтолцоог

нэгдмэл, шаталсан бүтэцтэйгээр зохион байгуулах, сургалтын агуулга, арга зүй, хэрэгжүүлэгч этгээд, хяналт үнэлгээний ерөнхий шаардлагыг тодорхойлоход оршино.

3.2 Зарчим

- 3.2.1 Аж ахуйн нэгж, байгууллага, сургалтын байгууллагууд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н тухай хууль, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”, үндэсний эсвэл олон улсын стандарт аргачлалын дагуу зохион байгуулна.
- 3.2.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах, удирдлагаар хангах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн байгууллагын дарга болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил хариуцсан ажилтан хэсэг, нэгжид тэдгээрийн дарга (мастер) хариуцна.
- 3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /ажил олгогч, нийт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан/ сургалтын хөтөлбөрийг ажил олгогч баталсан байна
- 3.2.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /эрсдэлтэй ажлын байрны сургалт, ХАБЭА-н ажилтан бэлтгэх/ сургалтыг жишиг хөтөлбөрт нийцүүлэн сургалтын төрөл бүрээр хөтөлбөр боловсруулж, төрийн захиргааны уг асуудал хариуцсан байгууллагаар батлуулсан байна.
- 3.2.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг Монгол Улсын хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлсэн шинжлэх ухаан, технологийн дэвшилтэд аргачлалыг ашиглах зарчмыг баримтална.
- 3.2.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь энэхүү стандартын 3.3-д заасан ерөнхий шаардлагыг хангасан тохиолдолд хүчин төгөлдөрт тооцогдоно.

3.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага

- 3.3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /ажил олгогч, нийт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, эрсдэлтэй ажлын байрны сургалт, ХАБЭА-н ажилтан бэлтгэх/ сургалтыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан сургалтын байгууллага батлагдсан журам, энэхүү стандартын дагуу хийнэ.
- 3.3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга барил эзэмшүүлэх үйлдвэрлэлийн дадлагыг дадлага хийх зориулалтын газар (цех, тасаг)-т буюу ажлын байранд хэсэг, цехийн дарга, мастер, өндөр мэргэжилтэй ажилтан, мэргэжлийн багш удирдаж хийлгэнэ.

4 Сургалтын төрөл

- 4.1 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, коллежийн боловсролын хөтөлбөрт зориулсан ХАБЭА-н сургалт

- 4.2** Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, иргэн болон ажил олгогчид зориулсан ХАБЭА-н сургалт
- 4.2.1 Ажил олгогчийн сургалт
 - 4.2.2 Нийт ажилтны сургалт
 - 4.2.3 Эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилтанд зориулсан сургалт
 - 4.2.4 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалт
 - 4.2.5 ХАБЭА-н ажилтны сургалт
 - 4.2.6 Ажлын байран дахь зааварчилгаа
- 5** **Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, коллежийн оюутан, сурагчид зориулсан ХАБЭА-н сургалт**
- 5.1** Цэцэрлэгийн насны хүүхдэд осол, аюулын талаар анхдагч зөв ойлголт өгөх тоглоом наадгай, ахуйн хэрэгсэл, материалтай харьцах, зөв болон бурууг ялгах чадвар олгох, аливаа үзэгдэл, хөдөлгөөнийг зөв гүйцэтгэх, ариун цэвэр эрүүл ахуйн анхны хэвшил төлөвшүүлэх ажлыг сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.
 - 5.2** Бага боловсрол эзэмших суралцагчдад аливаа аюултай, хортой үзэгдэл, юмс, эрүүл ахуйн талаар анхан шатны мэдлэг олгож, түүнийгээ амьдрал ахуйдаа хэрэглэх чадал чадвартай болгохын зэрэгцээ түүнийг өөрийн болон бусдын хөдөлмөрийн хүндэтгэх үзлээр хүмүүжүүлнэ.
 - 5.3** Суурь боловсрол эзэмших суралцагчдад аливаа хортой, аюултай үзэгдэл юмсын талаар шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлж, түүний үндсэн дээр өөрийн мэдлэг чадвараа цаашид хөгжүүлж, бие даан ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар дадлыг олгох ба аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам, дүрмийг чанд сахидаг үзлээр хүмүүжүүлнэ.
 - 5.4** Бүрэн дунд боловсрол эзэмших суралцагчдад хими, физик, биологийн аюултай ба хортой хүчин зүйлийн тухай шинжлэх ухааны ойлголт, хуулиудыг танин мэдүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан аюулгүй ажиллах арга барилд сургах, чадвар дадал олгохын зэрэгцээ хууль ёсыг дээдлэн сахидаг үзэл төлөвшүүлнэ.
 - 5.5** Их сургууль, коллежийн суралцагчдад, ялангуяа үйлдвэрлэл, техник технологи, анагаах ухаан, эрүүл ахуйн чиглэлээр мэргэжиж байгаа суралцагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар онолын үндсийг эзэмшүүлж, түүнийг амьдрал, хөдөлмөрт төлөвшүүлнэ. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, бусдыг сургаж зааварчлах чадвар, дадал эзэмшүүлнэ.
 - 5.6** Их сургууль, коллежийн дээд боловсролын дипломын болон бакалаврын зэргээр төгсөх оюутны дипломын төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар нэг хэсэг болгон тусгаж, улсын шалгалтын комисс үнэлэлт өгнө.
 - 5.7** Их сургууль, коллежийн дээд боловсролын дипломын болон бакалаврын зэрэг олгох сургалтын төлөвлөгөөнд тусгах ХАБЭА-н холбогдолтой хичээлийн кредит цаг, агуулгыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага, холбогдох мэргэжлийн бусад байгууллагатай хамтран боловсруулан мөрдүүлнэ.

6 Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, иргэн болон ажил олгогчид зориулсан ХАБЭА-н сургалт

6.1 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан (шат шатны удирдах ажилтан), шинээр аж ахуй эрхлэх гэж буй хүмүүс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тусгай сургалтад хамрагдсан байна.

6.2 Өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмж химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа зэрэг хөдөлмөрийн онцгой нөхцөлд ажиллах ажилтныг мэргэжлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тусгай хөтөлбөрөөр сургаж, үнэмлэх олгох ба зохих эрх аваагүй ажилтныг ажиллуулахыг хориглоно.

7 Ажлын байран дахь зааварчилгаа

7.1 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр зохион байгуулна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа дараах 2 хэлбэртэй байна. Үүнд:

1. Анхан шатны зааварчилгаа

2. Давтан зааварчилгаа

7.2 Анхан шатны зааварчилгааг шинээр ажилд орсон ажилтан, ажлын байран дахь ажилтны ажилладаг хэсэг, цех, тасаг, ажлын байр өөрчлөгдөх, мөн үйлдвэрлэлийн дадлага, үйл ажиллагаатай танилцахаар ирсэн ажилтан, оюутан, сурагч, зочинд өгнө

7.3 Анхан шатны зааварчилгааны агуулга 2 төрөл байна.

7.3.1 Ерөнхий мэдлэг олгох буюу хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, заавар, стандарт, тухайн байгууллагын өвөрмөц онцлог, дотоод дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно.

7.3.2 Байгууллагын онцлогт нийцүүлсэн ХАБЭА-н мэдлэг олгох буюу тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах, журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ,

гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно.

- 7.4** Анхан шатны зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн кабинет, сургалтын техник хэрэгслээр тусгайлан тоноглогдсон анги, танхимд уг асуудлыг хариуцсан ХАБЭА-н ажилтан эсвэл удирдах буюу инженер техникийн ажилтан өгнө.
- 7.5** Байгууллагын онцлогт нийцүүлсэн ХАБЭА-н мэдлэг олгох зааварчилгааг тухайн ажлын байрыг хариуцсан цех, тасаг, хэсгийн дарга, эрхлэгч биечлэн үзүүлэх журмаар өгнө.
- 7.6** Анхан шатны зааварчилгаа өгөх хугацаа нь тухайн техник технологийн салбарын аюулгүй ажиллагааны дүрэмд заасан хэмжээгээр тогтоогдох бөгөөд 2 цагаас багагүй байна.
- 7.7** Анхан шатны зааварчилгаа өгсний дараа зааварчилга өгсөн ажилтан шалгалт авч хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.
- 7.8** Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө.
- 7.9** Давтан зааварчилга нь гурван хэлбэртэй байна. Үүнд:
 - 7.9.1 ээлжит
 - 7.9.2 ээлжит бус
 - 7.9.3 ажлын байран дахь өдөр тутмын
- 7.10** Ээлжит давтан зааварчилгааг улиралд нэгээс доошгүй удаа өгнө.
- 7.11** Ээлжит бус давтан зааварчилгааг шинэ технологи, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм заавар, шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилга өгөх ээлжит хугацаанаас нь өмнө өгнө.
- 7.12** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчин, хурц хордлого гарсан цех тасаг, хэсгийн ажилтан нарт, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилга өгнө.
- 7.13** Аюултай ажил гүйцэтгэдэг хүмүүст ажлын байран дахь өдөр тутмын зааварчилга өгнө. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгөгдөнө.
- 7.14** Ажлын байран дахь анхан шатны, давтан болон ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааны бүртгэл (хавсралтын 1, 2-р хүснэгт)

ТӨГСӨВ.

А Хавсралт
(Мэдээллийн)

Хүснэгт А.1

**Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны
бүртгэлийн маягт**

№	Анхан шатны зааварчилга авсан хүний овог, нэр, албан тушаал	Заавар- чилгааны утга	Он, сар, өдөр	Шалгалтын дүн	Зааварчилга өгсөн хүний албан тушаал, гарын үсэг	Зааварчилга авсан хүний гарын үсэг	Ажиллуулахыг зөвшөөрсөн	
							Албан тушаал, овог, нэр	Гарын үсэг
1.								
2.								
3.								

Хүснэгт А.2

**Ажлын байран дахь давтан
зааварчилгааны бүртгэлийн маягт**

№	Ажилтны овог нэр, ажил, албан тушаал	Давтан зааварчилга өгсөн шалтгаан	Зааварчилг ааны сэдэв	Он, сар, өдөр	Зааварчилга өгсөн хүний албан тушаал нэр, гарын үсэг	Зааварчилга авсан хүний гарын үсэг
1.						
2.						
3.						